



УЛААНБААТАР ХОТЫН
ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨВ ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6.1, Засгийн газрын 1999 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 4 дүгээр хэсгийн 4.9.9, Хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төвийн албан хаагчдын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх сургалтыг 2018 онд батлагдсан төлөвлөгөөний дагуу 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулахыг Хүний нөөц, дотоод асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн /Х.Эрдэнэбаяр/-д даалгасугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 275.000 /хоёр зуун далан таван мянга/ төгрөгийг Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /М.Ичинхорлоо/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Н.Батсүх/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАН-ОЧИР